



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

“Үндэсний хувцас өмсөх өдөр”-ийн тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн 2025 оны III хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үндэсний бахархлыг иргэн бүрийн үйл хэрэгт шингээж, түүнд тулгуурлан үндэсний эв нэгдлийг төлөвшүүлэх, өв соёлоо түгээн дэлгэрүүлж, сурталчлах зорилгоор долоо хоног бүрийн “Даваа” гарагийг дүүргийн харьяа төр захиргааны байгууллага, хамт олны хүрээнд “Үндэсний хувцасаа өмсөх өдөр” болгон зохион байгуулахыг дүүргийн Засаг дарга (Н.Мандуул)-д чиглэл болгосугай.

2. “Үндэсний хувцас өмсөх өдөр”-ийг байгууллага, хамт олны хүрээнд зохион байгуулж, хамтран ажиллахыг дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж, байгууллагуудад уриалсугай.

3. Энэ захирамжийг дүүргийн иргэд, олон нийтэд түгээн сурталчлахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба (П.Баянбаатар), Засаг даргын Тамгын газар (Ж.Лхагвасүрэн)-т даалгасугай.

ДАРГА



Т.УЛАМБАЯР